



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2015/04



Статистикийн хэрэглэгч та бүхэн манай хэвлэмэл бүтээгдэхүүн болон тоо мэдээллүүдийг MONSTAT, ezStat аппликейшнуудээр дамжуулан Apple-ын iPhone, iPad төхөөрөмжтэй бол App store-с, андройд үйлдлийн системийн төхөөрөмжтэй бол Google play-с татан авч, суулгаж ашиглах боломжтой.



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**4 сар
2015**

Баруун-Урт сум



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	3
Аргачлалын тайлбар	4-5
Товч танилцуулга	6-12
Үндсэн үзүүлэлтүүд.....	13
I. Нийгмийн үзүүлэлт	
I.2 Хөдөлмөр.....	13-16
I.3 Нийгмийн халамж.....	17
I.4 Эрүүл мэнд.....	18-19
I.5 Гэмт хэрэг.....	20-21
II. Эдийн засгийн үзүүлэлт	
II.1 Мөнгө, банк.....	22
II.2 Төрийн санхүү.....	23-24
II.3 Үнэ.....	25-26
II.4 Хөдөө аж ахуй	27-30
II.5 Аж үйлдвэр	31-33



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэлгээ:

Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-II зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй	x	Бүтцийн өөрчлөлт
0.0 Маш бага тоо	+, -	Зөрүү
- Гүйцэтгэл байхгүй	*	Дахин

┌ "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. 15-14 нь 2015 оны үзүүлэлтийн тухайн оны үзүүлэлтээс өсч, буурсан абсолют өөрчлөлт.

V. "Төл" нь төлөвлөгөө, "Гүйц" нь гүйцэтгэл.

VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- **Хөдөлмөр:** Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
- **Эрүүл мэнд, Гэмт хэрэг:** Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- **Эрүүгийн хуульд** эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.



- **Хэрэглээний үнийн индекс / ХҮИ / гэдэг нь** хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.
 - Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- **Мөнгө, банк:** Монгол банк арилжааны банкуудаас мэдээг авч нэгтгэн, банкуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- **Төрийн санхүү:** Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.
- **Хөдөө аж ахуй:** Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- **Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцохдоо: гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



Сүхбаатар аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2015 оны 4 дугаар сарын байдлаар)


I. Нийгмийн үзүүлэлт



I.1 Хүн ам

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээгээр эхний 4 дүгээр сард 471 хүүхэд шинээр мэндэлж, 96 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 375 болж 2014 оны мөн үеэс 24.2 хувиар буюу 73-аар өслөө. 1000 хүнд ногдох төрөлт 8.3, нас баралт 1.7 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.6 пунктээр өсч, нас баралт 0.6 пунктээр буурсан байна.

Зураг.I.1 Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо




I.2 Хөдөлмөр

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2015 оны 4 дүгээр сарын эцэст 810 болсны 361 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажил хайгчдын 769 нь ажилгүй иргэд байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.5 хувь буюу 19 хүнээр, 2014 оны 12 дугаар сарын эцсээс 3.2 хувь буюу 24 хүнээр тус тус өссөн байна.

Эхний 4 дүгээр сарын байдлаар хөдөлмөрийн хэлтэст 450 иргэн шинээр бүртгүүлсний 77 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Зураг.I.2 Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд





Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 65.5 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 15.6 хувь нь дээд, 2.9 хувь нь тусгай дунд, 5.1 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 58.4 хувь нь бүрэн дунд, 14.3 хувь нь суурь, 2.6 хувь нь бага боловсролтой, 1.2 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Зураг.1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшингээр,
4 дүгээр сарын байдлаар



Эхний 4 дүгээр сарын байдлаар 76 шинэ ажлын байр бий болсны дотор үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар 30 буюу 39.5 хувь, боловсруулах үйлдвэрийн салбар 21 буюу 27.6 хувийг тус тус эзэлж байгаа нь өндөр үзүүлэлтэй байна.



1.3 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас нийт 2.1 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 14.5 мянган иргэнд олгосноос халамжийн сангаас 1.2 тэрбум төгрөгийг 10.9 мянган иргэнд, улсын төсвөөс 0.9 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор мянган иргэнд тус тус олгожээ.



1.4 Эрүүл мэнд


Аймгийн хэмжээнд эхний 4 дүгээр сарын байдлаар 83.5 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар буурч, 4.2 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 23.0 мянган хүн хамрагдсан нь 38.5 хувиар буурлаа.

Түргэн тусламжийн дуудлага 5.5 мянган удаа гарсны 1.4 мянга буюу 25.5 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал алсын дуудлага 26.3 хувиар буурсан байна.

Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 4 дүгээр сард 468 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 471 хүүхэд болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 40-өөр, хүүхдийн тоо 42-оор тус тус өссөн байна.



Зураг.I.4 Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо



Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо эхний 4 сард 261 болж, өмнөх оны мөн үеийнхээс 56 хүн буюу 27.3 хувиар өсөхөд цусан суулга, салхинцэцэг, сүрьеэ, зэрэг өвчлөгчдийн тоо өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нялхсын эндэгдэл энэ оны 4 дүгээр сард 7 болж, өмнөх оны мөн үеийнхээс 3 хүүхдээр буурч, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 болж өмнөх оны мөн үеийнхтэй ижил байна.




I.5 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 2015 оны 4 дүгээр сард 125 гэмт хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 13 хүн нас барж, 57 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 4-өөр буурсан байна. Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 264.3 сая төгрөгийн хохирол учирсны 81.9 хувийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 124 хүн холбогдон сэжиглэгдсэний 19.4 хувь нь согтуугаар хэрэг үйлджээ.

Нийт 230 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 533 хүн буюу 69.9 хувиар буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 46 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Зураг.I.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо





II. Эдийн засгийн үзүүлэлт




II.1 Мөнгө, банк:

Монгол банкны мэдээгээр ХААН, Төрийн, Хас, Голомт, Капитал банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 94.3 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 1.2 тэрбум төгрөгөөр буюу 1.3 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 18.6 тэрбум төгрөгөөр буюу 24.6 хувиар өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 34.5 тэрбум төгрөг болж оны эхнээс 0.5 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 1.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл эхний 4 сарын эцэст 0.8 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.8 хувийг эзэлж байна.

Зураг.II.1. Зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламжийн үлдэгдэл, 4 сарын эцэст, тэрбум.төг




II.2 Төрийн санхүү:

Аймгийн төсвийн нийт орлого эхний 4 сард 15.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.2 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар, төсвийн зарлага санхүүжилт 13.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.7 тэрбум төгрөг буюу 16.4 хувиар буурчээ.

Аймгийн нэгдсэн төсвийн 13.0 хувийг татварын орлого, 1.6 хувийг татварын бус орлого, 85.4 хувийг тусламжийн орлого эзэлж байна.


Зураг.II.2 Төсвийн орлого, зарлага, тэрбум.төг



**II.3 Хэрэглээний үнийн индекс**

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2015 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 9.2 хувь, жилийн эцсээс 2.9 хувь, өмнөх сараас 0.5 хувиар тус тус өслөө.

Зураг.II.3 Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)

**Хүснэгт.II.1 Хэрэглээний үнийн индекс, бүлгээр**

Бараа үйлчилгээний бүлэг	<u>2015.IV</u> 2014.IV	<u>2015.IV</u> 2014.XII	<u>2015.IV</u> 2015.III
Ерөнхий индекс	109.2	102.9	100.5
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	110.9	105.5	102.2
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	110.2	100.2	100.0
Хувцас, бөс бараа, гутал	105.5	100.4	100.0
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	137.3	116.6	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	108.9	99.8	100.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	102.9	100.7	100.1
Тээвэр	105.8	100.0	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	96.8	99.6	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	102.6	101.1	100.1
Боловсролын үйлчилгээ	107.6	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	104.3	100.8	100.0
Бусад бараа, үйлчилгээ	106.2	102.8	100.0

Ерөнхий индекс өмнөх сарынхаас 0.5 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 2.2 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ 0.1 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.



II.4 Хөдөө аж ахуй

Мал төллөлт төл бойжилт. 2014 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1.2 сая хээлтэгч малын 69.7 хувь буюу 850.2 мянган хээлтэгч 2015 оны эхний 4 дүгээр сарын сарын байдлаар төллөсөн байна. Таван төрлөөр нь авч үзвэл: эм хонь 74.0 хувь, эм ямаа 72.6 хувь, үнээ 46.1 хувь, гүү 39.7 хувь, ингэ 29.3 хувь төллөжээ.

Гарсан төлийн 99.2 хувь болох 849.5 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 206.9 мянга буюу 32.1 хувиар өссөн байна.

4 дүгээр сарын байдлаар төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл: унага, тугал 99.6 хувь, хурга 99.3 хувь, ботго, ишиг 99.0 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс ботго, унага, тугал 0.1-0.7 пунктээр өсч, харин хурга, ишиг 0.1 пунктээр буурсан байна.

Зураг-II.4.1 Төллөсөн хээлтэгчийн тоо, сумаар, мян.толгой, 2015 оны эхний 4 дүгээр сарын байдлаар




Зураг-II.4.2 Бойжуулсан төлийн тоо, сумдаар, мян.толгой, 2015 оны эхний 4 дүгээр сарын байдлаар



Малын онд оролт: Том малын зүй бус хорогдол 2015 оны 4 дүгээр сард 8.4 мянган толгой болж, өмнөх оны мөн үеэс 1.2 мянган толгойгоор буюу 16.3 хувиар өссөн байна. Том малын хорогдлыг төрлөөр нь авч үзвэл: тэмээ 19, адуу 717, үхэр 419, хонь 3798, ямаа 3489 толгой байна. Малын нийт хорогдлын 44.9 хувийг хонь эзэлж байна.



Зураг-II.4.3 Том малын зүй бусын хорогдол



Аймгийн хэмжээнд хорогдсон нийт мал оны эхний малын 0.3 хувийг эзэлж байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон малын 2.7 хувь буюу 228 толгой мал хорогдож өмнөх оны мөн үеэс 90.4 хувиар буурчээ.



II.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 9.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 0.5 тэрбум төгрөг буюу 4.8 хувиар буурчээ. Ангиллаар нь өмнөх онтой харьцуулан авч үзвэл: боловсруулах аж үйлдвэрийнх 164.9 сая төгрөг буюу 10.0 хувиар өсч, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 6.9 тэрбум төгрөг буюу 4.2 хувь, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 2.8 тэрбум төгрөг буюу 9.7 хувиар тус тус буурлаа.

Оны үнээр 59.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос 24.7 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс хүрэн нүүрс, дулаан, цахилгаан, бялуу, талх хийжүүлсэн цэвэр ус, рашаан, хэвийн боов, монгол дээл, хэрчсэн гурил, ажлын хувцас, монгол гутал, пальто, хүрэм, туурга, гэрийн бусад модон тавилга ширмэн болон төмөх зуух, яндан зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өнгөрсөн оны мөн үеэс өссөн байна.

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

	Хэмжих нэгж	2013	2014	2015	Зөрүү	$\frac{2015}{2014}$ %
Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд						
Төрсөн хүүхэд	хүн	404	429	471	42	109.8
Нялхасын эндэгдэл	хүн	10	10	7	- 3	70.0
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	182	750	769	19	102.5
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	476	205	261	56	127.3
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	103	129	125	- 4	96.9
Хэрэгт холбогсод	хүн	91	108	124	16	114.8
Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт						
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй						
харьцуулснаар, хувиар	хувь	102.8	104.9	102.9	- 2.0	98.1
Иргэдийн хадгаламж	сая.төг	30 483.0	35 999.5	34 524.3	-1 475.2	95.9
Зээлийн өрийн үлдэгдэл	сая.төг	51 445.0	75 654.4	94 302.0	18 647.6	124.6
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	13 761.7	15 592.4	15 393.9	- 198.5	98.7
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	11 003.3	16 193.0	13 526.3	-2 666.7	83.5
Төлөлсөн хээлтэгч	тол	696 282	642 801	850 184	207 383	132.3
-Ингэ	тол	779	802	965	163	120.3
-Гүү	тол	15 931	21 302	27 336	6 034	128.3
-Үнээ	тол	19 943	25 829	34 500	8 671	133.6
-Эм хонь	тол	378 603	354 856	465 063	110 207	131.1
-Эм ямаа	тол	281 026	240 012	322 320	82 308	134.3
Бойжуулсан төл	тол	696 919	642 634	849 464	206 830	132.2
-Ботго	тол	767	789	955	166	121.0
-Унга	тол	15 780	21 197	27 230	6 033	128.5
-Тугал	тол	19 823	25 649	34 380	8 731	134.0
-Хурга	тол	378 948	354 835	464 853	110 018	131.0
-Ишиг	тол	281 601	240 164	322 046	81 882	134.1
Том малын зүй бусын хорогдол	тол	13 488	7 259	8 442	1 183	116.3
- Тэмээ	тол	33	18	19	1	105.6
- Адуу	тол	366	106	717	611	676.4
- Үхэр	тол	900	2 525	419	-2 106	16.6
- Хонь	тол	5 910	2 196	3 798	1 602	173.0
- Ямаа	тол	6 279	2 414	3 489	1 075	144.5
Үүнээс: Өвчнөөр хоргдсон мал	тол	264	2 370	228	-2 142	9.0
- Тэмээ	тол	-	1	1	-	-
- Адуу	тол	15	2	1	- 1	50.0
- Үхэр	тол	81	2 366	27	-2 339	29.2
- Хонь	тол	68	-	148	148	30.2
- Ямаа	тол	100	1	51	50	5100.0
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая.төг	10 675.1	10 393.2	9 861.7	- 531.5	94.9
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая.төг	39 515.1	34 506.5	59 206.4	24 699.9	171.6

**I.2 ХӨДӨЛМӨР****I.2.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар**

Сум	2013.XII	2014.XII	2013.IV	2014.IV	2015.IV	$\frac{2015.IV}{2014.IV} \%$
Асгат	14	33	-	13	13	100.0
Баяндэлгэр	37	46	14	38	17	44.7
Дарьганга	24	9	17	15	10	66.7
Мөнххаан	17	16	1	8	6	75.0
Наран	13	14	1	18	5	27.8
Онгон	25	39	5	53	5	9.4
Сүхбаатар	36	33	12	25	14	56.0
Түвшинширээ	14	32	1	31	16	51.6
Түмэнцогт	70	26	-	35	13	37.1
Уулбаян	26	12	25	14	8	57.1
Халзан	22	9	27	21	8	38.1
Эрдэнэцагаан	31	66	1	39	44	112.8
Баруун-Урт	434	410	78	440	610	138.6
Дүн	763	745	182	750	769	102.5

I.2.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр							Насны бүлгээр					
			Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Асгат	13	5	4	-	-	8	1	-	-	6	6	1	-	-	-
Баяндэлгэр	17	12	2	-	1	6	7	-	1	5	8	1	2	1	-
Дарьганга	10	7	6	-	-	3	1	-	-	2	5	2	1	-	-
Мөнххаан	6	4	3	-	-	3	-	-	-	-	6	-	-	-	-
Наран	5	4	1	-	-	3	1	-	-	3	1	-	1	-	-
Онгон	5	2	1	-	-	3	1	-	-	2	3	-	-	-	-
Сүхбаатар	14	7	3	1	-	8	2	-	-	7	3	2	1	1	-
Түвшинширээ	16	12	2	2	2	5	5	-	-	5	7	2	1	1	-
Түмэнцогт	8	3	2	-	-	8	3	-	-	2	5	5	-	1	-
Уулбаян	8	2	1	-	-	2	3	2	-	1	1	4	2	-	-
Халзан	44	13	-	1	-	6	1	-	-	3	4	1	-	-	-
Эрдэнэцагаан	13	8	3	-	4	30	5	1	1	13	12	15	3	1	-
Баруун-Урт	610	261	92	18	32	364	80	17	7	115	279	146	58	10	2
Дүн	769	340	120	22	39	449	110	20	9	164	340	179	69	15	2



I.2.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2013.I-XII	2014.I-XII	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV	$\frac{2015.I-IV}{2014.I-IV} \%$
Асгат	107	89	-	6	8	133.3
Баяндэлгэр	174	173	18	25	-	-
Дарьганга	110	42	11	-	4	-
Мөнххаан	69	57	-	7	5	71.4
Наран	83	37	9	6	-	-
Онгон	168	95	10	34	1	2.9
Сүхбаатар	110	134	7	22	-	-
Түвшинширээ	176	100	-	37	11	29.7
Түмэнцогт	108	89	-	35	5	14.3
Уулбаян	119	74	-	7	9	128.6
Халзан	104	74	32	5	2	40.0
Эрдэнэцагаан	74	233	-	36	29	80.6
Баруун-Урт	1848	1 218	45	214	376	175.7
Дүн	3 250	2 415	132	434	450	103.7

I.2.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮНИЙ ТОО, сумаар

Сум	2013.I-XII	2014.I-XII	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV	$\frac{2015.I-IV}{2014.I-IV} \%$
Асгат	75	46	-	7	6	85.7
Баяндэлгэр	98	88	7	20	8	40.0
Дарьганга	31	25	-	-	-	-
Мөнххаан	43	20	-	-	1	-
Наран	37	9	8	-	-	-
Онгон	113	17	6	5	1	20.0
Сүхбаатар	29	95	2	21	2	9.5
Түвшинширээ	162	34	-	8	14	175.0
Түмэнцогт	37	29	-	6	7	116.7
Уулбаян	82	53	-	13	1	7.7
Халзан	62	53	14	2	2	100.0
Эрдэнэцагаан	18	95	-	-	9	-
Баруун-Урт	977	478	1	90	26	28.9
Дүн	1 764	1 042	38	172	77	44.8



I.2.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо		Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилалаа										
			ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас агнуур	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	Мэдээлэл, холбоо	Боловсрол	удирдлагын олон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Урлаг, үзвэр, тоглоом наадам	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Бусад
	2014 I-IV	2015 I-IV											
Асгат	-	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
Баяндэлгэр	-	9	-	-	-	-	-	-	-	-	1	8	-
Дарьганга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Мөнххаан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Наран	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Онгон	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	-	2	-	1	-	-	-	1	-	-	-	-	-
Түвшинширээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Түмэнцогт	-	7	-	-	-	-	-	-	-	-	-	7	-
Уулбаян	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Халзан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баруун-Урт	-	57	3	20	5	4	-	2	9	-	-	14	-
Дүн	-	76	3	21	5	4	-	3	9	-	1	30	-

**I.3 НИЙГМИЙН ХАЛАМЖ****I.3.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая.төг**

Үзүүлэлт		2015. I-IV	
		Хүн тоо	сая.төг
Халамжийн сан	1 Халамжийн тэтгэвэр	1 307	591.3
	2 Халамжийн тэтгэмж	620	70.2
	Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд 1 удаа	605	48.6
	3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд 1 удаа	-	-
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	1	1.2
	Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа	9	10.8
	2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	2	4.0
	Нэг удаагийн тусламж	3	3.6
	Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	-	-
	3 Амжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 006	232.1
	Ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	569	108.0
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	206	46.9
	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	95	23.6
	Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	11	4.8
	Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	10	2.5
	Хүүхэд, төрөл садангүй ганц бие ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	22	4.4
	16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	93	40.2
	4 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	22	0.1
	Ахмад настны нийгмийн хамгаалалын тухай хуулийн дагуу олгогдож		
	5 байгаа хөнгөлөлт тусламж	3 401	133.6
	6 ХБ-тэй иргэнд олгогдож буй хөнгөлөлт, тусламж	276	50.9
	7 Хүнс тэжээлийн хөтөлбөрийн зардал	4 227	85.9
Улсын төсвөөс	1 Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	1 540	218.1
	2 Алдар эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	5 079	682.1
	3 Алдар цолтой ахмадуудад олгосон хөнгөлөлт тусламж	14	4.9
	ДҮН	17 492	2 074.4

**I.4 ЭРҮҮЛ МЭНД****I.4.1 ЭРҮҮЛ МЭНД**

	Хэмжих нэгж	2014.I-IV	2015.I-IV	Өсөлт	
				тоо	%
1. Нийт үзлэг	мян.хүн	108.6	83.5	-25.1	76.9
2. Ор хоног	мян.хүн	39.4	34.8	-4.6	88.3
3. Урьдчилан сэргийлэх үзлэг	мян.хүн	37.4	23	-14.4	61.5
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	4.6	4.2	-0.4	91.3
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	7.0	5.5	-1.5	78.6
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.9	1.4	-0.5	73.7
6. Осол гэмтлийн дуудлага	хүн	182	169	-13	92.9
7. Нийт нас баралт	хүн	127	96	-31	75.6
8. Амаржсан эх	хүн	428	468	40	109.3
Үүнээс: амьд төрсөн хүүхэд	хүн	429	471	42	109.8
9. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	10	7	-3	70.0
10. 1-5 хүртлэх насны эндсэн хүүхэд	хүн	2	2	-	100.0

I.4.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

Сум	Амаржсан эх	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Асгат	1	1	-	-
Баяндэлгэр	6	6	-	-
Дарьганга	2	2	-	-
Мөнххаан	2	2	-	-
Наран	-	-	-	-
Онгон	2	2	-	1
Сүхбаатар	-	-	-	-
Түвшинширээ	-	-	-	1
Түмэнцогт	-	-	-	-
Уулбаян	-	-	1	-
Халзан	-	-	-	-
Эрдэнэцагаан	14	14	-	-
Баруун-Урт	441	444	6	-
Дүн	468	471	7	2



I.4.3 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ, сумаар

Халдварт өвчин	Хэмжих нэгж	2014.I-IV	2015.I-IV	Өсөлт	
				тоо	%
Вируст гепатит	хүн	9	6	-3	66.7
Цусан суулга	хүн	5	6	1	120.0
Бруцеллёз	хүн	1	3	2	3.0*
Салхинцэцэг	хүн	9	75	66	8.3*
Сүрьеэ	хүн	20	29	9	145.0
Тэмбүү	хүн	47	41	-6	87.2
Заг	хүн	65	38	-27	58.5
Трихоминиаз	хүн	45	41	-4	91.1
Бусад	хүн	4	22	18	5.5*
Бүгд	хүн	205	261	56	127.3

I.4.4 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

Сум	Халдвар өвчнөөр өвчлөгчид бүгд			Вируст гепатит	Цусан суулга	Бруцеллёз	Салхинцэцэг	Сүрьеэ	Тэмбүү	Заг	Трихоминиаз
	2014.I-IV	2015.I-IV	1000 хүн тутамд								
Асгат	7	9	5.2	-	-	-	-	3	-	4	2
Баяндэлгэр	2	51	10.7	-	-	-	49	2	-	-	-
Дарьганга	4	3	1.0	-	-	-	-	2	-	-	1
Мөнххаан	4	3	0.7	-	-	-	-	-	1	-	1
Наран	-	6	3.9	-	-	-	-	1	-	3	1
Онгон	8	10	2.7	-	-	-	-	1	4	2	3
Сүхбаатар	14	6	1.9	-	-	-	-	-	1	1	4
Түвшинширээ	3	8	2.5	-	-	-	-	1	-	3	3
Түмэнцогт	4	3	1.3	-	-	-	-	1	-	-	2
Уулбаян	13	2	0.7	-	-	-	-	1	1	-	-
Халзан	24	2	1.3	-	-	-	-	1	1	-	-
Эрдэнэцагаан	1	17	2.6	2	-	-	-	5	4	1	4
Баруун-Урт	121	141	7.5	4	6	3	26	11	29	24	20
Дүн	205	261	4.5	6	6	3	75	29	41	38	41

**I.5 ГЭМТ ХЭРЭГ****I.5.1 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, төрлөөр**

Хэргийн төрөл	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV
Бүртгэгдсэн хэрэг-бүгд	103	129	125
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	28	34	45
Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	2	2	2
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	38	56	57
Бусдын эд хөрөнгийг хулгайлах	28	38	43
Үүнээс: Хувийн өмчийг хулгайлах	14	23	30
Малын хулгай	12	14	12
Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	1	4	1
Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх	4	11	9
Аж ахуйн эсрэг гэмт хэрэг	1	1	1
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	17	16	9
Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	-	-	1
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	9	14	7
Бусад гэмт хэрэг	9	6	3
Гэмт хэргийн улмаас учирсан хохирол			
Гэмтэж осолдсон хүн	38	53	57
Нас барсан хүн	6	12	13
Нийт хохирол /сая.төгрөг/	223.9	128.9	264.3
Нөхөн төлүүлсэн хохирол /хувь/	70.6	43.0	81.9

I.5.2 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, сумаар

Сум	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV
Асгат	3	5	5
Баяндэлгэр	1	2	3
Дарьганга	5	2	7
Мөнххаан	9	10	11
Наран	1	5	3
Онгон	2	5	4
Сүхбаатар	7	4	10
Түвшинширээ	-	-	2
Түмэнцогт	7	4	4
Уулбаян	2	5	1
Халзан	1	2	3
Эрдэнэцагаан	19	15	12
Баруун-Урт	46	70	60
Дүн	103	129	125



I.5.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО

Сэжигтэн, яллагдагчийн тоо	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV
Бүгд	91	108	124
Үйлдэхдээ:			
-Бүлэглэсэн	9	29	24
-Согтуу байсан	34	49	24
Урьд ял шийтгэгдсэн	1	-	1
Эрүүлжигдсэн	942	763	230
Үүнээс: Баривчлуулсан хүн	90	66	46

I.5.4 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО, сумаар

Сум	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV
Асгат	1	4	4
Баяндэлгэр	1	2	3
Дарьганга	5	2	8
Мөнххаан	7	6	13
Наран	1	4	3
Онгон	1	6	4
Сүхбаатар	6	1	11
Түвшинширээ	-	-	1
Түмэнцогт	8	1	4
Уулбаян	2	5	1
Халзан	1	-	3
Эрдэнэцагаан	19	14	12
Баруун-Урт	39	63	57
Дүн	91	108	124

**II.1 МӨНГӨ, БАНК****II.1.1 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст, сая.төг**

Банк	Зээлийн өрийн үлдэгдэл			Хадгаламжийн үлдэгдэл		
	2013.XII	2014.IV	2015.IV	2013.XII	2014.IV	2015.IV
ХААН	58 300.3	47 556.2	57 430.6	17 498.6	18 795.1	17 050.7
ХАС	4 423.5	3 700.7	4 412.9	3 914.6	4 153.1	4 107.0
Голомт	5 835.0	4 156.1	5 089.5	1 195.4	1 122.4	1 207.3
Төрийн банк	26 535.0	20 241.4	26 405.6	11 344.8	11 928.9	12 057.6
Капитал банк	420.2	-	963.4	66.8	-	101.7
Дүн	95 514.0	75 654.4	94 302.0	34 020.2	35 999.5	34 524.3

II.1.2 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тооцооны төвүүдээр, сая.төг

Сум	Зээлийн өрийн үлдэгдэл			Хадгаламжийн үлдэгдэл		
	2013.XII	2014.IV	2015.IV	2013.XII	2014.IV	2015.IV
Асгат	1 311.6	935.2	1 391.1	1 117.4	1 065.8	1 188.1
Баяндэлгэр	3 649.3	2 373.6	3 960.4	2 477.9	3 249.0	3 005.8
Дарьганга	2 079.2	1 509.4	2 080.9	2 120.3	2 140.5	2 197.7
Мөнххаан	4 382.9	3 318.5	4 237.5	1 662.4	2 062.8	1 798.3
Наран	1 606.9	941.2	1 527.7	1 076.9	1 171.0	1 137.1
Онгон	4 638.5	3 515.0	4 773.1	2 514.3	2 505.0	2 557.2
Сүхбаатар	3 674.5	2 712.8	3 769.2	1 057.6	892.5	1 151.2
Түвшинширээ	2 870.8	1 689.6	2 707.6	840.1	1 188.0	1 049.9
Түмэнцогт	7 765.3	2 371.5	2 326.9	1 631.3	1 337.0	1 346.0
Уулбаян	2 569.7	2 613.9	3 787.4	1 504.3	1 104.9	1 044.2
Халзан	3 361.5	943.4	1 371.1	808.5	763.0	827.7
Эрдэнэцагаан	1 314.9	6 663.2	7 927.3	690.1	2 132.5	1 903.4
Баруун-Урт	8 675.2	7 981.6	8 411.9	2 929.2	2 679.1	2 783.0
Бичигт	372.9	368.5	387.9	100.6	141.5	145.9
Төмөртэй	1 629.7	1 340.7	1 567.0	133.2	69.7	171.8
Салбар	45 611.1	36 376.3	44 075.0	13 356.1	13 497.2	12 217.0
Дүн	95 514.0	75 654.4	94 302.0	34 020.2	35 999.5	34 524.3

**II.2 ТӨРИЙН САНХҮҮ****II.2.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая.төг**

	2014.I-IV	2015.I-IV			$\frac{2015.I-IV}{2014.I-IV} \%$
		Төл	Гүйц	%	
А. Урсгал орлого	2 887.8	2 035.5	2 255.3	110.8	78.1
1. Татварын орлого	1 488.9	1812.4	2 005.4	110.6	134.7
1.1 Орлогын албан татвар	898.1	1 357.5	1 321.5	97.3	147.1
1.2 Өмчийн татвар	174.7	116.8	58.1	49.7	33.3
1.3 Дотоодын бараа үйлчилгээний татвар	23.1	22.3	56.7	2.5*	245.5
1.4 Бусад	393.0	315.8	569.1	180.2	144.8
2. Татварын бус орлого	1 398.9	221.9	243.9	109.9	17.4
3.Хөрөнгө борлуулсны орлого	7.4	1.2	6.0	5.0*	-
Б. Тусламжийн орлого	12 697.2	11 488.6	13 138.6	114.4	103.5
Нийт орлого ба тусламжийн дүн	15 592.4	13 524.1	15 393.9	113.8	98.7

II.2.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА,сая.төг

	2014.I-IV	2015.I-IV			$\frac{2015.I-IV}{2014.I-IV} \%$
		Төл	Гүйц	%	
1. Урсгал зардал	16 191.4	13 587.3	13 526.3	99.6	83.5
1.1 Цалин хөлс ба нэмэгдэл урамшил	5 788.3	6 613.7	6 193.1	93.6	107.0
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	630.5	731.2	682.0	93.3	108.2
1.3 Байр ашиглалттай холбоотой зардал	1 217.7	1 721.7	1 711.8	99.4	140.6
1.4 Хангамжийн бараа материал	242.7	213.4	184.5	86.5	76.0
1.5 Нормативт зардал	603.1	675.3	668.4	99.0	110.8
1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	106.2	63.2	49.8	78.8	46.9
1.7 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	353.0	189.7	276.1	145.5	78.2
1.8 Томилолт зочны зардал	66.5	55.9	49.6	88.7	74.6
1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	649.0	154.1	1 940.1	12.9*	2.9*
1.10 Нийгмийн халамж үйлчилгээний зардал	1 320.0	1 779.6	1 651.9	92.8	125.1
1.11 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	576.6	137.4	74.7	54.4	13.0
1.12 Төрөөс иргэдэд үзүүлсэн бусад, тэтгэмж, дэмжлэг	161.5	60.7	36.3	59.8	22.5
1.13 Хөрөнгө оруулалт	4 476.3	1 191.4	8.0	0.7	0.2
1.14 Их засвар	1.6	-	-	-	-
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	16 191.4	13 587.3	13 526.3	99.6	83.5



II.2.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар, оны үнээр, сая.төг

Сум	Орлого				ХАОАТ		АТБӨЯХ-ийн татвар		Газрын төлбөр	
	2014.I-IV	2015.I-IV								
		төл	гүйц	%	төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц
Асгат	22.3	23.2	29.1	125.4	21	21.4	1.3	5.7	0.1	0.5
Баяндэлгэр	47.9	52.9	51.1	96.6	46.8	48.4	2.0	4.0	0.1	0.3
Дарьганга	31.2	35.7	31.9	89.4	34.0	28.8	-	-	0.1	0.1
Мөнххаан	37.2	42.5	35.2	82.8	38.6	30.9	-	1.2	0.7	0.3
Наран	23.9	22.9	27.9	121.8	22.1	25.6	-	0.3	0.3	0.1
Онгон	67.9	101.6	97	95.5	97.9	91	0.6	0.9	0.2	0.6
Сүхбаатар	41.1	37.4	45.6	121.9	30.8	32.9	-	0.02	6.0	3.7
Түвшинширээ	39.4	32.6	42.4	130.1	30.5	40.1	-	-	0.4	0.4
Түмэнцогт	194.2	35.5	67.1	189.0	33.1	39	-	1.5	1.5	1.7
Уулбаян	49.4	45.5	72	158.2	37.9	35.3	-	0.4	3.0	20.5
Халзан	23.4	23.4	19	81.2	21.9	17.6	-	0.1	0.2	0.2
Эрдэнэцагаан	129.7	136.3	153.8	112.8	128.7	139.4	-	5.8	2.5	2.4
Баруун-Урт	1 076.7	818.7	1 035.2	126.4	726.4	799.4	-	40.4	-	1.6
Сумын дүн	1 784.3	1 408.2	1 707.3	121.2	1 269.7	1 349.8	-	60.3	-	32.4
Аймгийн дүн	15 592.4	13 524.1	15 393.9	113.8	1 357.5	1 349.8	22.3	60.3	39.8	32.4

Тайлбар: Аймгийн Татварын хэлтсийн мэдээгээр

II.2.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар, оны үнээр, сая.төг

Сум	Зарлага				Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал		Хангамж бараа материалын зардал	
	2014.I-IV	2015.I-IV								
		төл	гүйц	%	төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц
Асгат	380.8	420.2	346.3	82.4	252.8	230.6	4.1	1.3	11.6	8.8
Баяндэлгэр	391.6	762.1	698.0	91.6	474.3	454.1	1.6	-	16.1	11.7
Дарьганга	531.1	523.6	458.1	87.5	319.4	303.2	1.5	0.6	15.4	11.0
Мөнххаан	781.5	625.5	579.9	92.7	428.6	411.2	2.3	0.1	14.4	8.9
Наран	352.6	402.9	340.6	84.5	275.8	256.9	1.1	0.7	8.6	7.0
Онгон	545.1	503.6	454.8	90.3	321.1	291.1	1.9	0.5	11.5	10.2
Сүхбаатар	565.1	439.8	397.2	90.3	270.7	246.7	2.0	0.5	7.0	5.1
Түвшинширээ	520.4	539.8	470.0	87.1	354.0	335.3	2.2	0.2	10.2	6.1
Түмэнцогт	919.5	556.7	495.3	89.0	336.9	312.9	2.4	0.9	12.9	8.7
Уулбаян	563.5	464.8	412.6	88.8	309.3	301.0	1.8	0.4	12.2	9.1
Халзан	403.9	392.4	370.2	94.3	273.7	270.2	1.7	0.4	8.9	6.5
Эрдэнэцагаан	854.6	813.2	747.2	91.9	538.5	515.2	1.0	0.3	20.3	17.0
Баруун-Урт	3144.6	3 360.5	3 094.0	92.1	1 712.4	1 566.9	6.9	3.0	33.0	21.1
Сумын дүн	9 954.3	9 805.1	8 864.2	90.4	5 867.5	5 495.3	30.5	8.9	182.1	131.2
Аймгийн дүн	16 193.0	13 587.3	13 526.3	99.6	6 613.7	6 193.1	154.1	1 940.1	213.4	184.5



II.3 ҮНЭ

II.3.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Барааны бүлгээр	2015.IV 2014.IV	2015.IV 2014.XII	2015.IV 2015.III
ЕРӨНХИЙ ИНДЕКС	109.2	102.9	100.5
ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	110.9	105.5	102.2
Хүнсний бараа	110.8	106.0	102.5
Талх, гурил, будаа	120.5	100.7	100.8
Мах, махан бүтээгдэхүүн	102.8	118.9	108.1
Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	101.0	100.7	96.7
Төрөл бүрийн өөх, тос	105.0	100.0	100.0
Жимс, жимсгэнэ	101.7	114.3	100.0
Төмс, хүнсний ногоо	112.8	111.5	107.0
Саахар, жимсний чанамал, чихэр, шоколад	103.7	99.9	97.3
Хүнсний бусад бүтээгдэхүүн	103.4	97.0	100.5
Согтууруулах бус ундаа	111.9	100.4	99.5
СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	110.2	100.2	100.0
Согтууруулах ундаа	107.2	100.4	100.0
Тамхи	112.2	100.0	100.0
ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	105.5	100.4	100.0
Хувцас, бөс бараа	105.2	100.1	99.9
Хөвөн бөс, бараа	96.9	100.0	100.0
Бүх төрлийн хувцас	105.5	99.9	99.8
Жижиг эдлэл, хэрэгсэл	107.1	106.7	100.0
Гутал	106.4	101.3	100.4
ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	137.3	116.6	100.0
Орон сууцны бодит түрээс	100.0	100.0	100.0
Орон сууцны засвар, үйлчилгээ	112.4	100.0	100.0
Усан хангамж, бусад үйлчилгээ	138.3	138.3	100.0
Цахилгаан, хийн болон бусад түлш	165.3	130.1	100.0
ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	108.9	99.8	100.0
Тавилга, хэрэгсэл, хивс, дэвсгэр	108.7	98.6	100.0
Оёмол, нэхмэл эдлэл	116.4	100.3	100.0
Цахилгаан бараа	103.3	99.8	100.0
Шилэн эдлэл, сав суулга	116.9	102.0	100.0
Багаж хэрэгсэл	114.7	103.3	100.0
Цэвэрлэгээний болон бусад жижиг бараа	106.0	99.4	100.0
ЭМ, ТАРИА, ЭМНЭЛЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	102.9	100.7	100.1
Эм, тариа, эмнэлэгийн хэрэгсэл	103.9	101.0	100.2
Амбулаторийн үйлчилгээ	106.4	100.0	100.0
Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх үйлчилгээ	100.0	100.0	100.0
ТЭЭВЭР	105.8	100.0	100.0
Тээврийн хэрэгслийн худалдан авалт	115.3	100.0	100.0
Хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	100.0	100.0	100.0
Тээврийн үйлчилгээ	103.9	100.0	100.0
ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	96.8	99.6	100.0
АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	102.6	101.1	100.1
Дуу, дүрс, гэрэл зураг, бусад тоног төхөөрөмж	99.9	100.2	100.2
Чөлөөт цаг, соёлын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Ном, сонин бичгийн хэрэгсэл	120.0	107.2	100.0
БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	107.6	100.0	100.0
ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	104.3	100.8	100.0
Нийтийн хоолны үйлчилгээ	103.6	101.4	100.0
Зочид буудал, дотуур байрны үйлчилгээ	105.3	100.0	100.0
БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	106.2	102.8	100.0
Хувь хүнд хандсан үйлчилгээ	105.8	103.3	100.0
Хувь хүний эд зүйл, хэрэглэл	111.8	100.0	100.0
Санхүүгийн үйлчилгээ	100.0	100.0	100.0



II.3.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны үнэ, сараар

Нэр төрөл	2013.IV	2014.IV	2015.IV	$\frac{2015.IV}{2014.IV}$ %
1-р зэргийн гурил, кг	920	980	1 250	127.6
Хонины мах, кг	7 250	6 900	7 150	103.6
Үхрийн мах, кг	7 650	7 400	7 900	106.8
Ямааны ястай мах, кг	6 325	5 900	6 100	103.4
Элсэн чихэр, кг	1 520	1 580	1 708	108.1
Цагаан будаа, кг	1 530	2 158	2 194	101.7
Шингэн сүү, л	1 625	1 800	1 760	97.8
Цагаан ноолуур, кг	60 250	76 600	53 400	69.7
Бор ноолуур, кг	60 250	76 600	53 400	69.7
Бензин, А-80, 1 литр	1 690	1 660	1 660	100.0
Бензин, А-92, 1 литр	1 930	1 920	1 920	100.0
Дизел түлш, литр	1 960	1 950	1 950	100.0

II.3.3 ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

Нэр төрөл	2013.IV	2014.IV	2015.IV	$\frac{2015.IV}{2014.IV}$ %
Тэмээний эр ноос	7 000	4 500	-	-
Тэмээний эм ноос	3 250	3 500	-	-
Адууны дэл	2 000	2 600	4 000	153.8
Адууны сүүл	7 000	5 500	5 000	90.9
Тэмээний шир	7 000	-	-	-
Адууны шир	30 000	19 000	32 500	171.1
Үхрийн шир 1.8-2.3 метрийн хэмжээтэй	22 500	27 500	27 500	100.0
Үхрийн шир 2.3 метрээс дээш хэмжээтэй	35 000	35 000	37 500	107.1
Хонины ноостой нэхий	4 750	5 000	1 500	30.0
Ямааны ноолууртай арьс	-	2 500	750	30.0
Сонгино	1 200	1 200	1 100	91.7
Сармис	4 100	4 000	3 500	87.5
Өргөст хэмх	2 900	3 500	2 750	78.6
Улаан лооль	2 850	3 600	3 850	106.9
Тарвас	-	-	2 450	-
Өндөг	300	400	350	87.5

**II.4 ХӨДӨӨ АЖ АХУЙ****II.4.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр**

Малын төрөл	Төллөсөн хээлтэгч, толгой			Төллөлтийн хувь		
	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV
Ингэ	779	802	966	22.1	23.7	29.4
Гүү	15 931	21 302	27 336	29.6	35.2	39.7
Үнээ	19 943	25 829	34 500	33.8	39.1	46.1
Эм хонь	378 603	354 856	465 063	75.7	63.4	74.0
Эм ямаа	281 026	240 012	322 320	74.5	60.1	72.6
Бүгд	696 282	642 801	850 185	70.0	59.0	69.7

II.4.2 МАЛ ТӨЛЛӨЛТ, сумаар

Сумд	Төллөсөн хээлтэгч, толгой			Төллөлтийн хувь		
	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV
Асгат	29 286	17 039	33 485	69.7	44.0	73.9
Баяндэлгэр	90 254	60 381	111 377	71.7	43.3	68.9
Дарьганга	43 082	43 988	47 703	71.1	71.7	72.8
Мөнххаан	85 253	91 368	115 628	78.2	76.2	82.1
Наран	29 943	27 524	41 075	69.1	57.4	75.5
Онгон	50 147	57 000	77 312	57.3	55.5	68.5
Сүхбаатар	50 597	52 204	62 877	64.8	60.4	68.3
Түвшинширээ	72 103	83 848	95 863	77.2	75.4	76.9
Түмэнцогт	22 677	19 480	14 353	70.1	60.3	39.4
Уулбаян	58 489	55 931	62 147	75.1	62.0	65.2
Халзан	32 803	25 691	41 802	68.3	50.7	75.5
Эрдэнэцагаан	61 885	62 185	36 916	70.7	72.4	40.4
Баруун-Урт	69 763	46 162	109 647	64.3	37.7	76.3
Бүгд	696 282	642 801	850 185	70.0	59.0	69.7



II.4.3 ТӨЛ БОЙЖИЛТ, төлийн төрлөөр

Малын төрөл	Бойжуулсан төл, толгой			Бойжилтын хувь		
	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV
Ботго	767	789	956	98.5	98.3	99.1
Унага	15 780	21 197	27 230	99.1	99.5	99.6
Тугал	19 823	25 649	34 380	99.4	99.3	99.6
Хурга	378 948	354 835	464 853	99.4	99.4	99.3
Ишиг	281 601	240 164	322046	99.1	99.1	99.0
Бүгд	696 919	642 634	849 465	99.3	99.3	99.2

II.4.4ТӨЛ БОЙЖИЛТ, сумаар

Сумд	Бойжуулсан төл, толгой			Бойжилтын хувь		
	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV
Асгат	28 682	16 890	33 124	97.8	99.1	98.9
Баяндэлгэр	93 242	60 451	111 377	99.6	99.8	100.0
Дарьганга	42 637	44 055	47 768	99.0	99.7	99.6
Мөнххаан	84 246	90 526	116 504	97.7	96.8	97.8
Наран	29 845	27 541	41 174	99.3	99.5	99.6
Онгон	50 248	57 170	78 025	100.0	100.0	100.0
Сүхбаатар	50 239	53 104	62 075	99.3	100.0	98.2
Түвшинширээ	72 401	83 932	95 549	100.0	99.7	99.3
Түмэнцогт	22 519	19 466	13 073	99.0	99.7	91.1
Уулбаян	58 826	55 674	62 127	99.7	99.4	99.7
Халзан	32 803	25 691	41 802	100.0	100.0	100.0
Эрдэнэцагаан	61 817	62 146	36 916	99.9	99.9	100.0
Баруун-Урт	69 414	45 988	109 951	99.3	99.2	100.0
Бүгд	696 919	642 634	849 465	99.3	99.3	99.2



II.4.1 ЗҮЙ БУСЫН ХОРОГДОЛ ТОМ МАЛ, малын төрлөөр

Малын төрөл	Хорогдол бүгд			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV
Тэмээ	33	18	19	0.3	0.2	0.2
Адуу	366	106	717	0.2	0.1	0.3
Үхэр	900	2 525	419	0.6	1.5	0.2
Хонь	5 910	2 196	3 798	0.5	0.2	0.3
Ямаа	6 279	2 414	3 489	0.7	0.3	0.3
Бүгд	13 488	7 259	8 442	0.6	0.3	0.3

II.4.2 ЗҮЙ БУСЫН ХОРОГДОЛ ТОМ МАЛ, сумаар

Сум	Хорогдол бүгд			Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь		
	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV
Асгат	1949	568	337	2.0	0.4	0.3
Баяндэлгэр	474	776	418	0.2	0.2	0.1
Дарьганга	785	962	181	0.6	0.6	0.1
Мөнххаан	1 758	2 135	1 749	0.7	0.3	0.6
Наран	137	318	118	0.1	0.3	0.1
Онгон	220	189	0	0.1	0.1	0.0
Сүхбаатар	105	28	2 250	0.1	0.0	1.0
Түвшинширээ	126	1 355	683	0.1	0.3	0.2
Түмэнцогт	2 359	135	2 280	3.3	0.1	2.8
Уулбаян	225	140	120	0.1	0.0	0.1
Халзан	338	104	72	0.3	0.0	0.1
Эрдэнэцагаан	4 646	263	225	2.3	0.0	0.1
Баруун-Урт	366	286	9	0.2	0.1	0.0
Бүгд	13 488	7 259	8 442	0.6	0.3	0.3



II.4.3 ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, малын төрлөөр

Малын төрөл	Өвчнөөр хорогдсон мал			Нийт хорогдсон малд эзлэх хувь		
	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV
Тэмээ	-	1	1	-	5.6	5.3
Адуу	15	2	1	4.1	1.9	0.1
Үхэр	81	2 366	27	9.0	93.7	6.4
Хонь	68	-	148	1.2	-	3.9
Ямаа	100	1	51	1.6	0.0	1.5
Бүгд	264	2 370	228	2.0	32.6	2.7

II.4.4 ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, сумаар

Сум	Өвчнөөр хорогдсон мал			Нийт малд эзлэх хувь		
	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV	2013.I-IV	2014.I-IV	2015.I-IV
Асгат	15	-	2	0.8	-	0.6
Баяндэлгэр	30	424	17	6.3	54.6	4.1
Дарьганга	3	754	7	0.4	78.4	3.9
Мөнххаан	5	2	-	0.3	0.1	-
Наран	14	254	-	10.2	79.9	-
Онгон	-	189	-	-	100.0	-
Сүхбаатар	-	-	-	-	-	-
Түвшинширээ	9	729	187	7.1	53.8	27.4
Түмэнцогт	1	1	-	-	0.7	-
Уулбаян	14	6	6	6.2	4.3	5.0
Халзан	24	5	-	-	4.8	-
Эрдэнэцагаан	-	3	-	-	1.1	-
Баруун-Урт	149	3	9	40.7	1.0	100.0
Бүгд	264	2 370	228	2.0	32.6	2.7

**II.5 АЖ ҮЙЛДВЭР****II.5.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая.төг**

Аж үйлдвэрийн салбар	2014.I-IV	2015.I-IV	Дүнд эзлэх хувь	
			2014.I-IV	2015.I-IV
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	7 148.9	6 948.0	68.8	70.5
Нүүрс	185.7	240.4	1.8	2.4
Цайрын баяжмал	6 963.2	6 707.6	67.0	68.0
Боловсруулах аж үйлдвэр	149.9	164.9	1.4	1.7
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт	85.3	97.2	123.2	1.0
Дээрхи ангид ороогүй бусад үйлдвэрлэл	64.6	67.7	0.6	0.7
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	3 094.4	2 748.8	29.8	27.9
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	3 025.1	2 643.2	29.1	26.8
Ус хуримтлуулах, ариутгах, усан хангамжийн үйл ажиллагаа	69.2	105.6	0.7	1.1
Дүн	10 393.2	9 861.7	100.0	100.0

II.5.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, оны үнээр, сая.төг

Аж үйлдвэрийн салбар	2014.I-IV	2015.I-IV	Дүнд эзлэх хувь	
			2014.I-IV	2015.I-IV
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	31 136.4	54 508.3	90.2	92.1
Нүүрс	363.1	743.2	1.1	1.3
Цайрын баяжмал	30 773.4	53 765.1	89.2	90.8
Боловсруулах аж үйлдвэр	428.9	467.2	1.2	0.8
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэлт	310.4	347.7	0.9	0.6
Дээрхи ангид ороогүй бусад үйлдвэрлэл	118.5	119.5	0.3	0.2
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	2 941.2	4 230.9	8.5	7.1
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	2 750.8	3 994.3	8.0	6.7
Ус хуримтлуулах, ариутгах, усан хангамжийн үйл ажиллагаа	190.4	236.7	0.6	0.4
Дүн	34 506.5	59 206.4	100.0	100.0



II.5.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, оны үнээр, сая.төг

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	2014.IV	2015.IV	2014.I-IV	2015.I-IV	2015.I-IV 2014.I-IV %
Уул уурхай, олборлох аж үйлдвэр					
Хүрэн нүүрс	-	225.3	363.1	743.2	204.7
Цайрын баяжмал	2 472.6	4 690.6	17 026.8	19 717.4	115.8
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж					
Дулааны эрчим хүч	460.5	695.8	1 923.4	2 865.6	149.0
Түгээсэн цэвэр ус	32.4	51.2	141.7	179.7	126.8
Цахилгаан	190.1	242.9	827.4	1 128.7	136.4
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа, ус үйлдвэрлэл					
Аарц	0.8	-	1.1	1.0	93.0
Бялуу	3.7	4.3	10.5	11.7	111.3
Зайрмаг	10.5	0.4	10.5	0.4	4.0
Нарийн боов	11.5	9.8	66.7	55.4	83.0
Талх	42.8	52.7	155.5	195.5	125.8
Хиамны зүйл	1.4	0.8	6.6	3.5	53.3
Хийжүүлсэн цэвэр ус, рашаан	-	5.4	1.6	14.7	9.2*
Хэвийн боов	-	-	57.4	64.4	112.3
Хэрчсэн гурил	-	0.3	-	0.9	-
Хувцас үйлдвэрлэл					
Ажлын хувцас	-	-	-	2.0	-
Гар хийцийн оёмол эдлэл /Хөөрөгний дайлин г.м/	-	-	0.0	-	-
Дээлнээс бусад монгол хувцас	0.9	1.8	4.0	5.6	142.4
Монгол гутал	-	0.2	2.4	5.7	236.0
Монгол дээл,тэрлэг	10.3	7.9	78.9	71.8	90.9
Оёмол пальто	-	0.1	-	0.1	-
Оёмол хүрэм	0.1	0.1	0.8	1.1	129.2
Өмд	-	-	0.2	-	-
Туурга	1.6	1.6	4.9	10.0	202.8
Хүүхдийн платые	0.0	-	0.0	-	-
Юбка	0.1	-	0.1	-	-
Модон эдлэл					
Гал тогооны өрөөний модон тавилга	1.0	2.6	7.6	6.2	81.6
Гар урлал, сийлбэрийн зүйлс	-	-	0.6	-	-
Гэрийн бусад модон тавилга	0.4	0.4	1.1	1.9	176.9
Модон сандал	0.4	0.1	0.8	0.4	46.3
Төрөл бүрийн модон эдлэл	1.2	0.9	4.0	0.9	23.4
Төмөр эдлэл үйлдвэрлэл					
Гал зуух, хоолны төмөр эдлэл	1.6	1.7	7.5	6.2	82.7
Гэр ахуйн төмөр эдлэл	0.7	0.5	2.3	1.6	68.6
Ширмэн болон төмөр зуух, яндан	-	0.8	0.7	1.3	189.1
Бусад үйлдвэрлэл					
Ариун цэврийн цаас	0.6	0.2	1.1	0.6	58.0
Сувагжуулалт	11.8	15.2	48.6	57.0	117.2
Хүрмэн блок	2.7	-	2.7	-	-



II.5.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, төрлөөр

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2014.IV	2015.IV	2014.I-IV	2015.I-IV	$\frac{2015.I-IV}{2014.I-IV} \%$
Уул уурхай, олборлох аж үйлдвэр						
Хүрэн нүүрс	мян.тн	-	5.9	22.3	28.8	129.1
Цайрын баяжмал	мян.тн	6.9	7.7	33.8	32.5	96.2
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж						
Дулааны эрчим хүч	мян.Гкал	11.4	11.7	49.5	51.7	104.4
Түгээсэн цэвэр ус	мян.м3	17.6	16.4	71.6	68.8	96.1
Цахилгаан	Сая.квт	1.9	2.1	8.4	9.7	115.5
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа, ус үйлдвэрлэл						
Аарц	тн	0.4	-	0.5	0.4	80.0
Бялуу	тн	0.2	0.3	0.7	0.9	128.6
Зайрмаг	мян.ш	30.0	0.9	30.0	0.9	3.0
Нарийн боов	тн	5.1	3.3	17.1	14.4	84.2
Талх	тн	39.8	39.5	142.3	151.0	106.1
Хиамны зүйл	тн	0.2	0.1	1.0	0.5	50.0
Хийжүүлсэн цэвэр ус, рашаан	мян.л	-	29.2	8.0	80.5	10.1*
Хэвийн боов	тн	-	-	14.1	16.8	119.1
Хэрчсэн гурил	тн	-	0.2	-	0.4	-
Хувцас үйлдвэрлэл						
Ажлын хувцас	ш	-	-	-	40.0	-
Гар хийцийн оёмол эдлэл /Хөөрөгний дайлин г.м/	мян.төг	-	-	12.0	-	-
Дээлнээс бусад монгол хувцас	ш	23	34	119	175	147.1
Монгол гутал	хос	-	3	69	136	197.1
Монгол дээл, тэрлэг	ш	206	148	1 445	1 364	94.4
Оёмол пальто	ш	-	1	-	1	-
Оёмол хүрэм	ш	2	1	16	22	137.5
Өмд	ш	-	-	5	-	-
Туурга	ш	9	5	29	40	137.9
Хүүхдийн платые	ш	1	-	1	-	-
Юбка	ш	2	-	2	-	-
Модон эдлэл						
Гал тогооны өрөөний модон тавилга	ш	1	2	8	5	62.5
Гар урлал, сийлбэрийн зүйлс	ш	-	-	2	-	-
Гэрийн бусад модон тавилга	ш	4	1	9	11	122.2
Модон сандал	ш	50	11	104	32	30.8
Төрөл бүрийн модон эдлэл	мян.төг	1 210.0	930.0	3 970.0	930.0	23.4
Төмөр эдлэл үйлдвэрлэл						
Гал зуух, хоолны төмөр эдлэл	мян.төг	1 603.0	1 697.0	7 518.0	6 219.0	82.7
Гэр ахуйн төмөр эдлэл	ш	50	32	180	120	66.7
Ширмэн болон төмөр зуух, яндан	ш	-	4	5	8	160.0
Бусад үйлдвэрлэл						
Ариун цэврийн цаас	мян.ш	1.6	0.5	3.2	1.5	46.9
Сувагжуулалт	мян.м3	10.4	8.4	42.1	40.4	96.0
Хүрмэн блок	мян.ш	1.8	-	1.8	-	-



Хаяг: Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум
Аймгийн нутгийн удирдлагын ордон, 102, 103 тоот
Вэб сайт: <http://sukhbaatar.nso.mn>
Фесбүүк хуудас: <https://www.facebook.com/statistic>
Холбоо барих утас: 70518819, 70518203
И-мэйл: sukhbaatar@nso.mn, statistic_suh@yahoo.com

Үндэсний Статистикийн хорооны мэдээллийн сайт: <http://www.nso.mn>
Статистик мэдээллийн нэгдсэн сангийн сайт: <http://www.1212.mn>
Тооллогын мэдээллийн сангийн сайт: <http://arccgis.nso.mn>
Аймгийн мэдээллийн сайт: <http://sukhbaatar.mn>

СТАТИСТИК -
ХӨГЖИЛД ХӨТЛӨГЧ ХҮЧ